

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2017 ОНЫ
10 ДУГААР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ**

2017.10.12

ӨЛГИЙ

д\д	7 хоногийн ажлын товч мэдээлэл
01	Халамжийн 09 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн мөнгийг тарааж дуусгав.
02	Аж ахуйн нэгж байгууллагуудад 2017 оны 09-р сарын 26-ны өдрөөс эхлэн 2017 оны 10-р сарын 3-ны өдөр хүртэл “Ажлын байрны дэмжих хөтөлбөрт яаж хамрагдах вэ”, “Ажил хайгч иргэдийн хандлагыг яаж өөрчлөх вэ”, “Аймгийн шилдэг ажил олгогч байгууллага, ажил олгогч иргэнийг ААН-ийн оролцоотойгоор шалгаруулах” тухай гурван зорилготой зурган өдөр 2 цагийн хугацаатай сургалтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Б.Съезхан, аймгийн төвд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 65 аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, төлөөллүүд болон сургалт зохион байгуулах ажлын хэсэг оролцов. Уг сургалтын нээлтийн арга хэмжээг газрын дарга үг хэлж сургалтыг нээв. М.Гүлия мэргэжилтэн Ажлын байрны дэмжих арга хэмжээнд яаж хамрагдах талаар мэдээлэл өгсөн. Ажил хайгч иргэдийн хандлагыг яаж өөрчлөх үү сэдэвт мэдээлэл өгч сургалтыг хэлэлцүүлэг маягаар зохион байгуулав.
03	Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулав. Уг арга хэмжээнд 110 гаруй залуучууд бүртгүүлсэнээс 60 залуучуудыг сонгон авч сургалтанд хамруулав. Уг сургалтыг Старт ап Монголиа ТББ байгуулав. Уг сургалт нь 10.06-08 өдрийн хооронд үргэлжилж, сургалтын явцад 10 баг шалгаран хоорондоо уралдав. Нэгдүгээр байранд шалгарсан SAAKHAR багт-10,0 сая, хоёрдугаар байранд шалгарсан Энтерпрёнер багт-10,0 сая төгрөгийг ШХА-ийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр болсон юм. Гуравдугаар байранд 2 баг шалгарсан ба уг санхүүжилтийг Орон нутгийг хөгжүүлэх сангаас баталсан орон нутгийн дэд хөтөлбөр багтаан санхүүжүүлэхээр шийдвэрлэв.
04	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд шинээр 45 ахмадуудад гэрээ хийж үйл ажиллагааг нь эхлүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Уг арга хэмжээний хүрээнд Эрүүл мэнд, Боловсрол, Хөдөө аж ахуй, Төрийн захиргааны гэсэн 4 чиглэлээр зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулж байна.
05	Хөдөлмөрт бэлтгэх, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд “Хөдөлмөрт бэлтгэх арга” хэмжээг эрх бүхий сургалтын байгууллагаар зохион байгуулж нийт 120 иргэнийг хамруулав. Үүнд: Хорихоос суллагдсан, асрамжаас гарсан иргэн, 15-34 насны ажилгүй залуучууд, барилгын цэргийн ангийн халагдах цэргүүд болон ажил олоход хүндрэлтэй иргэд хамрагдав.
06	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Борлуулатын төвийн” засвар үйлчилгээг хянав. Хүнсний ногоо тариалах арга хэмжээний хүрээнд Алтанцөгц, Баяннуур сумуудад “Намрын ногоон өдрүүд” өдөрлөгийг зохион байгуулж, бүлгийн ажилуудад хяналт тавьж ажиллав. Нийтийг хамарсан ажлын хүрээнд Асрамжийн газрын нийтийн эзэмшлийн зам талбайг засаж залруулах ажлыг хийж, 10 хүн түр ажлын байраар хангагдав. Ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд шинээр 4 хувиараа хөдөлмөр эрхлэгчтэй гэрээ хийж, арга хэмжээнд хамруулав.

07	Жижиг зээл олгох арга хэмжээнд төсөл ирүүлсэн 12 иргэнтэй тодорхойлолт гаргаж, Голомт банк руу илгээв.
08	Аймгийн хэмжээнд зохион явуулсан гамшгаас урьдчилан сэргийлэх иж бүрэн сургалт болон үйл ажиллагаанд хариуцлагатай оролцож, үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэн ажиллав.

**МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА ГАРГАСАН:
ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА**

Д.АЛТЫНГҮЛ